



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/276

Алтай хот

Багш, ажилтныг чадавхжуулах,  
авлигаас урьдчилсан сэргийлэх сургалт зохион  
байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, 2021 оны "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр батлах тухай" 78 дугаар тогтоол, 2022 оны "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн 7.2.4 дахь заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд багш, ажилтныг чадавхжуулах, авлигаас урьдчилсан сэргийлэх сургалтыг зохион байгуулахад 1,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн "Багш нарыг чадавхжуулах, байр, сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ"-ний батлагдсан зардлаас гаргаж, хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР